

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АРВАН ТАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны дөрөвдүгээр сарын 23-ны 14 цаг 04 минутад эхэлж, 15 цаг 20 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 16 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Завхан, Дорноговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд Дорноговь, Завхан аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Дорноговь, Завхан аймагт 2015 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 48 иргэн /Дорноговь аймагт 5, Завхан аймагт 43/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 51 иргэн /Дорноговь аймагт 7, Завхан аймагт 44/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс</p>

		<p>хамгийн өндөр оноо авсан 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэн /Дорноговь аймагт 3, Завхан аймагт 10-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 19 иргэн /Дорноговь аймагт 5, Завхан аймагт 14/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 5, 6, 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 32 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөл /С.Бөххүү/-д, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөл /Д.Түвшинжаргал/-д тус тус үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал хэмжил зүйн газрын Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сары 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Баатарчулууны Ариунааг Засгийн</p>

		газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Стандартчилал, хэмжил зүйн газрын Г.Гантөмөрт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	УИХ-ын гишүүнээр 2000-2004 онд ажиллаж байсан Б.Баттулгыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 2000-2004 оны хооронд сонгогдон ажиллаж байсан Батаагийн Баттулгыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
4	Нөөцөөс хасах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь заалт, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн ХЭГ/784 тоот албан бичгийг тус тус баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Засгийн газрын тохируулагч агентлаг албан тушаалд томилогдох удирдах ажилтны нөөцийн жагсаалтаас иргэн хасах. 2. Энэ тогтоолыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод болон иргэн Д.Цогтбаатар нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн

		албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/682 тоот албан бичгээр Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд 2015 оны 4 дүгээр сарын 20-нд ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэв.
6	Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах тухай	Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ц.Мэндсайханы 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 106 тоот албан бичгээр Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
7	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар

		<p>ирүүлсэн саналыг хэлэлцээд, нэг албан хаагчид тэргүүн түшмэлийн хоёр албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.</p> <p>Ажлын хэсэг Улсын Их Хурлын тогтоол, журамд заасан шаардлагын дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн баримт бичгийг судалж үзэхэд тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулах нэг албан хаагч ийн материал шаардлага хангаагүй тул буцаахаар тогтлоо.</p>
8	Төрийн албаны зөвлөлийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны зөвлөлийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар тус Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Шатарбалын Раднаасэдийг томилох 2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 83 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох 3. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Ш.Раднаасэдэд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.